







СОЁЛЫН ЖИМЭЭР  
THE CULTURAL WAY

ЭРДЭМ

ШИНЖИЛГЭЭ

ᠡᠷᠳᠡᠮ



ᠰᠢᠨᠵᠢᠯᠭᠡᠭᠡ

Эрхэлсэн: Э.Итгэл

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР  
THE CULTURAL WAY

ISSN: 2791-1446

БОТЬ VI (№6)

**Редакцын зөвлөл:**

Доктор (Sc.D)	Д.Бадамдорж	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Чулуунбаатар	(Монгол)
Доктор (Ph.D)	Н.Мягмар	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Хурцбаатар	(Герман)
Доктор (Ph.D)	Л.Хасбаатар	(БНХАУ)
Доктор (Ph.D)	Б.Болд	(Япон)
Доктор (Ph.D)	Залгаабаяр	(БНХАУ)

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвийн

Эрдэм шинжилгээний редакцын зөвшөөрлөөр улирал тутам хэвлэгдэх сэтгүүл

Улаанбаатар 2023

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia





СОЁЛЫН ЖИМЭЭР  
THE CULTURAL WAY

**ISSN: 2791-1446**

**VOLUME VI**

**Editorial board:**

Doctor (Sc.D)	Badamdorj. D	(Mongolia)
Doctor (Ph.D)	Chuluunbaatar. L	(Mongolia)
Doctor (Ph.D)	Myagmar. N	(Mongolia)
Doctor (Ph.D)	Qurčabaatar. L	(Germany)
Doctor (Ph.D)	Qasbaatar. L	(China)
Doctor (Ph.D)	Bold. B	(Japan)
Doctor (Ph.D)	Zalgaabayar	(China)

**Edited by: Itgel. E**

THE CULTURAL WAY  
CENTER FOR CULTURAL STUDIES  
Printed with permission of editorial board  
a quarterly journal of research

Ulaanbaatar 2023

*ISSN: 2791-1446*

© *Sodon Soyod Publishing, Mongolia*



# СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

## ГАРЧИГ

1. **Л. Чулуунбаатар**  
*Шовгор харын тухай*.....1
2. **Кань Хай Ин**  
*Цаг үе ба амьдралын уриа дууч (Мао Дунь ба А.Одсэрийн туужис)*.....4
3. **Хань Хуйлин**  
*Мин Инзун хааны магад хууль дахь Түмүбао-ийн дайнтай холбогдсон түүхэн материалын ирэлтийн тухай товч өгүүлэх нь*.....25
4. **Жао Фа**  
*Монгол Хятадын хамтын эзнийг өргөмжлөх: Шадар сайдын яамны түшмэд ба улсыг уламжлах Хасбуу тамгаы учир*.....36
5. **С.Мягмарсүрэн**  
*Тунгалаг тамир МУСК нь түүх бичлэгийн өвөрмөц хэлбэр болох нь*.....64
6. **Ли Шяохун**  
*Чингийн үеийн Мао Да Ин хэмээх хүний тухай нотлол*.....75
7. **Наргил, Л.Хасбаатар**  
*Р.Чойномын зохиол бүтээлийн дундад улс дахь цаасан хэвлэл дамжуулгын зохиол бүтээлийн тухайд*.....86
8. **Э.Итгэл**  
*Дарьгангын хүн амын тухай товч өгүүлэх нь*.....94

## МЭДЭЭЛЭЛ

ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



# СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

## CONTENT

<b>1. Chuluunbaatar. L</b>	
<i>About the Shovgor Kharaz (tapered black).....</i>	<i>1</i>
<b>2. Kan Haiying</b>	
<i>The Motto of times and life.....</i>	<i>4</i>
<b>3. Han Huiling</b>	
<i>Historical material related to the Tumubao's war in Ming Yingzong laws.....</i>	<i>25</i>
<b>4. Zhao Fa</b>	
<i>Mongol and Han lords and Khasbuu stamp.....</i>	<i>36</i>
<b>5. Myagmarsuren. S</b>	
<i>The Tungalag tamir is a unique form of historiography.....</i>	<i>64</i>
<b>6. Li Xiaohong</b>	
<i>Facts about Mao Daying of the Qing empire.....</i>	<i>75</i>
<b>7. Nargil, Khasbaatar. L</b>	
<i>R.Choinom's paper dissemination in the China.....</i>	<i>86</i>
<b>8. Itgel. E</b>	
<i>Historical population of Dariganga.....</i>	<i>94</i>

## NEWS





# СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

## ЭРХЛЭН ХЭВЛҮҮЛЭГЧИЙН ҮГ

*Энэ удаагийн дугаарт ӨМИС-ийн Монгол Судлалын Дээд Сургууль, Монголын Үндэсний Их Сургуулийн эрдэмтэн багш, залуу судлаачдын өгүүллүүд багтлаа. Манай сэтгүүлийн алсын зорилго бол монгол улс дахь хөрш орнуудын залуу судлаач, эрдэмтдийн судалгааны төв цаашилаад монголын соёл судлалд зохих хувь нэмрийг оруулах явдал билээ. Тус дугаарт хэд хэдэн хятад үсгээр бичигдсэн өгүүллүүдийн агуулгын товчийг монгол хэлээр орчуулж, эх бэлтгэв. Монголоос кирилл бичигт хөрвүүлэх, хятад хэлнээс монгол хэлэнд орчуулах орчуулгын баг хамт олондоо талархал илэрхийлье. Халуун сэтгэлээр цаг бүр туслан дэмжих эрхэм номын садан ӨМИС-ийн доктор Бао Ургаацэцэг, Шаогуань Их Сургуулийн багш, доктор Жан Юань, ШУА-ийн ХЗХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан доктор Т.Батбямба болон бусад бүх номын ах эгч дүү, нөхөд, багш нартаа чин сэтгэлээсээ талархаж буйгаа энд тэмдэглэе. Бидний энэхүү ажилтай танилцан санал хүсэлт, шүүмж байваас харамгүй илгээхийг хичээнгүйлэн хүсье. Таны аливаа санал шүүмжийг бид мэхийн хүндэтгэж хүлээн авах болно.*

*Эрдэм шинжилгээний редакцын зөвлөлийн гишүүн*

*Э.Итгэл / Түүхийн ухааны докторант /*

*2023 оны 06 сар*



## ШОВГОР ХАРЫН ТУХАЙ

Л.Чулуунбаатар\*

2012 оны 7 сарын 15-ны өдөр Шонхор телевизээр Юүндэнгөөгөө, Сүнжидмаа дууны эвлүүлэг нэтрүүлж байв. Дуучид нь сэтгэл зүрхийг долгилуулан гэгээ татуулж, уянгатай сайхан дуулж байв. Клипээр гарч байгаа ноёны хувцас дээл малгай, гутал бүх зүйл зохицож, аятайхан харагдаж байгаа боловч хоёр хиа нь шовгор хар гутал өмссөн нь үйл явдал болоод цаг үетэйгээ зохицолдоогүй харагдаж байв. Энэ нь соёл түүхээ, зан заншлаа мэддэггүй найруулагчийн алдаа гэдэг нь илэрхий байна. Тэгээд нээрээ шовгор хар монголд хэзээ нэвтэрсэн талаар саналаа солилцмоор санагдлаа. Монголд анх нэвтэрч байх үед шовгор хар хэмээн нэрийдэж байсныг “Түмний нэг”, “Өглөө” кинонд тод харуулдагийг бид мэднэ. Харин одоо манай хөдөөний малчин ардууд болон цэрэг эрсийн гол хэрэглээ болсон байна. Ялангуяа бөх ширээр хийсэн хийгээд малчин ардууд маань морь унахад тохиромжтой болохоор маш дуртай хэрэглэдэг байна.

Тийм болохоор хийсэн материалаас нь болоод бахиал, хороом гэх мэтээр нэрлэж байна. Бахиал нь орос хэлний бахила, бахилы хэмээсэн үг бөгөөд монгол хэлэнд авиа дуудлагаар идээшиж бахиал болсон байна. Бахиалыг цэрэг эрс болон ажил төрөл хийхэд өмсдөг нь эдэлгээ даадаг бөх бат учир тэр юм. Харин хороом нь грек гаралтай *chrōma* гэсэн үг бөгөөд савхи, нимгэн булигаар гэсэн утгатай хийгээд англи хэлээр *boxcalf boots* хэмээн нэрийдэх боловч оросоор дамжиж *хромовые сапоги* нь хороом болоод, голдуу гоёлд өмсөх гутал болжээ. Энэ шөвгөр хар анх Х зууны үед туркийн нүүдэлчдээс орос болон ойрх дорнодод нэвтэрчээ. Эхлээд мэдээж дээдэс ноёдын дунд дэлгэрсэн нь мэдээж хэрэг юм. Тэгээд орост 1917 он гэхэд л дөнгөж бүх эрчүүд нь гутал өмсдөг болсон байна. Гэхдээ Игорын хорооны цэрэглэсэн туужийн үед былина хэмээх гутал байсныг оросын түүхийн сурвалжууд гэрчилж байна. Анхны сандаалын мөр НТӨ 500.000 жилийн тэртээд хамаардаг байна. Харин гутлын анхны мэдээ бол АНУ-ын Орегон муж улсын Форт рокийн агуйгаас олдсон бөгөөд үүнийг радио рентгений

\* МҮИС-ийн багш, доктор профессор



## THE CULTURAL WAY

аппаратаар тодорхойлж үзэхэд 10.000 гаруй жилийн өмнөх хэмээн тодорхойлсон байна. Гутлын хувьд монголчууд аль эрт Хүннүгийн үеэс уламжлалтай бөгөөд учир нь хүчирхэг морин цэрэгтэй байсан тул морь унахад зохимжтой, холын аянд хөл холгохгүй, өвөлийн хүйтэнд удаан хугацаанд хөл дааруулахгүй өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой гуталтай байсан юм. Чингисийн үеийн цэргийн гутал түрийнийхээ дунд давхар төмөр хамгаалалттай байсныг бид Улсын түүхийн музейгээс үзэж болно. Харин шовгор хар бол XX зууны эхэн үе буюу 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын дараа оросын худалдаачдыг дагаж нэвтэрсэн боловч монгол хүний өргөн хэрэгцээ болж чадаагүй байсан бөгөөд 1921 оны Ардын хувьсгалын үр нөлөөгөөр орос орноос өргөнөөр нэвтэрэн ирэх болсон байна. Гэхдээ л дөчөөд он хүртэл сэхээтнүүд, цэрэг эрс, албан хаагчид, сурагч оюутан нар өмсч байсан байна. Эхэн цагтаа арьс, модоор хийж байсан бол орчин үед пластик, нэхмэл, төмөр, хаймар зэрэг янз бүрийн материалаар хийх болжээ.

Оросоор сапоги, англиар footwear хэмээдэг байна. Энэ нь утгаа хөлийн өмсгөл хэмээх гол утгаа агуулж байгаа юм. Харин орчуулагчид shoes хэмээгээд байдаг нь голдуу түрийгүй, шагай хүрсэн гутал буюу шаахайг хэлж байгаа хэрэг болно. Шаахай хэмээх нь хятад хэлний хie hai хэмээх үг бөгөөд хятадын худалдаачдаар дамжиж монгол хэлэнд орсон үг байна. Оросоор бол ботинки юм. Хэдийгээр монгол хэлэнд гутал гэдэг ерөнхий нэрийн дор хөлд угладаг бүгдийг нэрлэдэг боловч гадаад хэл рүү тохирох үгээр нь орчуулна гэдэг нь утгыг зөв буулгаж, хэлний соёлыг эрхэмлэж байгаа бас нэг эрхэм зүйл мөн. Ялангуяа гуталтай холбоотой өвөрмөц хэлц, зүйр цэцэн үгийг зөв орчуулна гэдэг нь монгол соёлоо бусдад нэвтрүүлэх нэг гол түлхүүр юм. Ийм үгс монгол хэлэнд нийлээд буй.

Жишээлбэл: “Уул үзээгүй хормой шуух, ус үзэлгүй гутлаа тайлах” гэсэн зүйр үг байх бөгөөд энэ нь юмны учир начрыг ололгүй яаран сандран юм хийхийг оролдох, яаруу сандруу, бодлогогүй гэсэн утгыг гаргана уу гэхээс үгчилж орчуулж болохгүй юм. Англиар бол “Catch the bear before you sell his skin”, “Laugh before breakfast you will cry before supper”, “Don’t cross the bridges before you come to them” гэх мэтийн хэллэгүүдээр орчуулбал утга нь сайхан таарна. Мөн “Гутлаа шаахайнаас солих” гэсэн хэлц байна. Хуцаа ухнаас солих, хөхүүрээ боривноос солих, алтаа гуулинаас солих, хадгаа самбайнаас солих гэх мэтийн хэлцтэй нэг утгатай бөгөөд ашигтай зүйлээ ашиггүй зүйлээр солих гэсэн утгатай юм. Англиар бол “Give a lark to catch a kite” гэсэн хэллэгээр орчуулж болох юм. “Гутлаа чирсэн амьтан” гэсэн хэллэг





## THE CULTURAL WAY

байна. Англиар бол “a poor man” юмуу “pauper” хэмээх үгээр утга дүйлгэн орчуулахаас шууд орчуулбал инээдтэй явдал болно. Энэ нь доожоогүй, жавхаагүй, бүтэлгүй хэмээх утгыг илтгэх бөгөөд бүр цаашлавал ажилгүй, мэдлэггүй гэх утгыг ч дам илтгэнэ. Энэ нь өргөжөөд “Гунхсан сайхан нь намайг тоохгүй, гутлаа чирсэнийг нь би тоохгүй, гурвын дундах нь надад олдохгүй” гэсэн үг гарсан байна. Англиар бол “A handsome man doesn’t like me. I don’t like a pauper. But the middle one couldn’t be found by me” гэсэн утгаар буулгаж болох юм. Социализмын үед монголчууд гутал хийж зарим хэрэгцээгээ хангадаг байсан бодовч ардчилсан хувьсгалын дараа байхгүй болж харин оронд нь хувийн гутлын үйлдвэрүүд бий болсон байна. Гэхдээ л бид дэлхий дахины янз бүрийн гутлыг өмсч хэрэгцээгээ хангасаар байна. Харин Юүндэнгөөгөөгийн үед хиа нар монгол гутлаа өмсч байсан нь маргаангүй түүхийн үнэн юм. Иймд хуучны түүхтэй холбоотой кино, клип, баримтат кино алив зүйлийг бүтээхдээ түүхийг, тэр цаг үеийн соёлыг судалж байж хийх нь хойч үедээ түүхийн үнэнийг мэдүүлэх зайлшгүй шаардлагатай уялдсан бодит хэрэгцээ мөн болно.



**ЦАГ ҮЕ БА АМЬДРАЛЫН УРИА ДУУЧ**

*- Мао Дунь ба А.Одсэрийн туужис*

Кан Хай Ин\*

**ХУРААНГУЙ**

Хувьсгалт уран зохиолын төлөөлөгч Мао Дунь-ий тухайн үеийн ардчилсан хувьсгалд маш их нөлөө үзүүлсэн бөгөөд дундад улсын ахуйч үзлийн утга зохилын хөгжилтийн түүхэн дээр цоо зам нээгчийн үйлдлийг үзүүлсэн байна. Монгол үндэстэний од үеийн нартай зохиолч А.Одсэр ба Мао Дунь-ий туужист хүүрнэлийн хараасын талаас цаг үе хийгээд амьдрал давхцасан хувьсгалын хүүрнэлийн хараа, агуулга зохиомжийн бүрэлдцын талаас байгаль ахуйн зураглал, агуулга сэдэвлэхүүний тэлэлтийн талаас эмэгтэйчүүдийн тухай сэдэвлэхүүн зэрэг талаар хоёр зохиолыг харьцуулан судалж, хоёр зохиолчийн зохиол бүтээлийн адилшил шинжийг хайн сүвэгчлэв.

**Түлхүүр үгс:** *Мао Дунь, А.Одсэр, хүүрнэлийн хараа, агуулга бүрэлдэц, утга сэдэвлэхүүн*

Мао Дунь бол дундад улсын шинэ соёлын хөдөлгөөний зохион байгуулагч бөгөөд удирдагч, уран зохиолын дархан бөгөөд утга урлагийн шүүмжлэгч, дундад улсын олон үндэстний нийгэм журамт уран зохиолын садан мөн. Мао Дунь бол олонд мэдрэгдсэн үзэмжийг зураглах их багш, шинэ дундад улс байгуулагдсаны дараах 30 жилийн турш гол урсгалын зохиол бүтээлийн аргын үндэслэгч бөгөөд төлөөлөгч юм. Өнгөрсөн зууны 30-аад оны үед хотын сэдэвт туужис нь Мао Дунь-ий урлагийн үйлдлийн дунд, нэн баялаг шинэ аянаа эхлүүлсэн байдаг. “Шөнө дөл” романд 30-аад оны дундад улсын нийгмийн шинж чанар, зөрчил тэмцэл, ахуй байдал зэргийг нэлээд гүнзгий тусгасан бөгөөд ялангуяа үндэстний хөрөнгөтөн ангийн хувь заяа, үнэн төрх байдал зэргийг тун нарийн гүйцэд харуулжээ. Шөнө дөл нь бүхэлдээ 30-аад оны эхэн үеийн орчин үеийн дундад улсын дүр байдлын түүх болно. “Хиртэл”, “Замхрал”, “Гуйвалзал”, “Хөөцөлдөл” нь их хувьсгалын үеийн цаг үеийн бодит байдал жич шинэ цагийн сэхээтнүүдийн оюун санааны байдлыг тусгаж, Хиртэлтэй харьцуулбал Солонго нь цаг үет чанарыг илэрхийлэх талаар сэдэвлэлттэй байж, түүхийн урагшлалт нь давшсан “бүлгэм”-ийн удирдлагаас тогтоогдоно гэдгийг чангатгасан байна. Тэр нь дундад улсын хувьсгалд эш

\* ӨМИС-ийн Монгол судлалын дээд сургуулийн багш, доктор (Ph.D)

Судалгааны чиглэл: *Харьцуулсан уран зохиол ба Дэлхийн уран зохиол*

• Энэхүү өгүүлэл нь Хятадын ФНШУА-ийн төслийн онцлох бүтээл. Баталгаажуулалтын дугаар. (21XZW036)



## THE CULTURAL WAY

сурвалжийн тогтолцоог байгуулж өгсөн, даруй хожмын уран зохиолын “дутагдсан цаг”-ийн домгийг үүдгэсэн байна<sup>1</sup>.

А.Одсэрийн туужис хүүрнэлийн нөхцөл байдлын талаас цаг үе ба амьдрал давхацсан хувьсгалын байдлаар хүүрнэн цаг төрийн хувьсгал улирлыг илтгэн, агуулга зохиомжийн бүрэлдэцийн талаас байгаль ахуйг зураглан, зохиогчийн үзэл сэтгэлгээгээ дам илэрхийлжээ. Өгүүлэлд хүүрнэлийн чиглэлийн талаас цаг үе хийгээд амьдрал давхацсан хувьсгалын байдал, агуулга зохиомжийн бүрэлдэцийн талаас байгаль ахуйн зураглал, агуулга сэдэвлэхүүний тэлэлт, эмэгтэйчүүдийн тухай сэдэвлэхүүн зэрэг талаар Мао Дүнх ба А.Одсэр нарын туужист адилсах шинж илэрсэн байна.

Нэг. Цаг үе ба амьдрал давхацсан хувьсгалын байдал – хүүрнэлийн чиглэл

Хувьсгалт уран зохиолын төлөөлөгч бол Мао Дүнх болно. Шөнө дөл роман бол нийгмийг илэрхийлсэн роман юм. Хот бол гадаадын хөрөнгөт ёс ба үндэстний хөрөнгөтөн ангийн Шөнө дөл доторх тэмцлийн гол байлдааны талбар мөн. Дундад улсын хотод аж ахуй нь голдуу гадаадын хөрөнгөт ёс, дундад улсын үндэстний хөрөнгөтөн анги жич хэсэг ноёгч феодалын аж ахуйгаар бүрэлдсэн байна. Хөдөө тосгон дахь уламжлалт аж ахуй аажмаар уруудах, хотын хөрөнгийн энгийн эргэлтэд уусаж чадахгүй байдаг. Хотын үндэстний хөрөнгө нь гадаадын хөрөнгийн түрэмгийлэлд, өөрийнхөө эзэн мэдэх чадавхаа алдаж, бүхийл дундад улсын аж ахуй нь аврах аргагүй ялагдлын байдалд оршино. Хот хөдөөгийн бүтцийн зохиол бүтээлийн загвар гэх ухагдахуунчилсан зохион бүтээлтийн загвар Мао Дүнх-ий энэ үеийн уран бүтээлд нэвтэрч, уран зохиолын зохион бүтээлтийн амьжирлалын хүч болж байгаа юм. Бүхийл цаг үеийн хувьсгалт уран зохиолын урсгалыг дагаж, Мао Дүнх-ий зохион бичдэг цаг үе ба туужсын тусгасан хувьсгалын ар үзэгдэлтэй хам цагийн шинж чанартай байдаг<sup>2</sup>.

Амьдралын дундах бага учраас хувьсгалын их хүслэнт байдлыг бүтээх нь Мао Дүнх-ий багаар ихийг харуулах, ихийн дунд багыг агуулах хос шугамын хүүрнэлийн чиглэл, аугаа их хувьсгалт цаг үе ба нарийн нягт энгийн амьдралын байдал нь бүх нөхцөлд доошлогдож байдаг. Нэг төрөл нь амьдрал дунд нуугдаж байгаа хувьсгал, даруй Мао Дүнх олон талын нарийн зураглалаар илрүүлэн гаргадаг. Нөгөө нь энгийн амьдралд хүртэх хувьсгал, түүний багаар ихийг харуулан аугаа хувьсгалт цаг үеийн нэг салбар болгодог. Энгийн амьдралаар чиглэл болгоход амьдралыг нарийн ажиглаж, амьдралын дундах зарим битүү хатуу нарийн зүйлсийн зураглалд хувьсгалын гол чиглэлийг олж харна. Цаг хийгээд орон солбицсон хүүрнэлийн бүтэц, нэг зүйл нь шууд хувьсгалын хэрэг үүсгэсэн нийтийн талбар, нөгөө нэг зүйл нь харьцангуй нууцлаг хувь хүний оршихуйн талбар болсон байна. Хувьсгал ба хайр дурлал зэрэгцсэн хүүрнэлийн загвар, хувьсгалын төлөө хайр дурлалаа

<sup>1</sup> 阎浩岗著：《茅盾丁玲小说研究》，人民出版社，2018年，第16页。

<sup>2</sup> 徐美容：《论茅盾小说中的「城乡结构」》，华东师范大学硕士学位论文，2014年，第40页。



## THE CULTURAL WAY

үрэгдүүлэх зарчмыг баримтлан, Мао Дунь-ий зохиол бүтээл нь цаг үе хувьсгалын урагшлалтыг дагалдан эмэгтэйчүүдийн асуудал ба ураг гэр бүлийн асуудлыг анхаарч, уншигчийн дур сонирхлыг татах арга нь даруй хоёулаа амьдралын хүрээ хэмжээнд буцсанаар илэрхийлэн, бодитой хайр дурлалын амьдралаар хувьсгалд шинэ агуулга ивээдэг. Хайр дурлал нь хувьсгалын төлөөх хүч болно, мөн ч хувьсгал ялагдахын нууц гарам байж, бас хувьсгалын нэг зүйлийн дэд бүрэлдэхүүн болдог билээ. Хувьсгалын хүүрнэлийг сонгон уран зохиолын хөгжлийн суурин газар болгох нь Мао Дунь-ий сүвэгчилж олсон хувьсгал ба уран зохиолын нэгэн адилтгалын цэг мөн, тэр нь уншигчдын бүлэг бүрэлдэхүүнтэй шилдэг хувьсгалын хүүрнэл бүхий туужсийг үүдгэсэн байна. Нэг талаар хөрөнгөтөн ангийн хилэн хорслоо зураглалын төв болгоход хүрвэл ажилчин ангийг зураглах ба магтах нь үгээгүй ангийн хувьсгалын эрхийг булаан авах тэмцлийн дунд хөрөнгөтөн анги дахь хорслын сэтгэлгээний зураглалыг товойлгож, үгээгүй ангийн үхэхээс айхгүй, баатарлаг тэмцэх зориг санаагаар ангийн суурь болгож, чөлөөлөхөөр үүрэг болгохтой эсэргүүцэлдэж байдаг. Нөгөө талаар хувь хүний үзэл ухамсар ажиглах үзэл нь ажилчин анги хийгээд тариачны ойлголт гүн биш, үзэл ойлголт нь баригдаж, хүний дүрийн зураглал нь бодит үйлдэл дунд хүчтэй байж, түүний ойлгох нь хотын амьдрал, дагууд нь үндэстний хөрөнгөтөн ангийг зурагладаг<sup>3</sup>. Дундад улсын үндэстний аж үйлдвэрийн түрэмгийлэл ба залгилт нь зохиол бүтээлд амьдлаг бодитой дүр төрөхөөр дамжин илрэн гарсан байна.

Шөнө дөл бол 20 дугаар зууны 30-аад оны үеийн Шанхайн түнэр харанхуй цаг үе, энэ нь яг сайхан үүр гэгээрэхээс өмнөх цаг үе, дундад улсын ард түмэн шөнө дөлийн шанхайн нийгмийн түнэр харанхуйгаас үүрийн гэгээнд итгэж, Шөнө дөлийн үзэл санаа агуулгын бүтэц болсон байна. Шөнө дөлийн нийгэмд ариун цэвэр хайр сэтгэл нь зоос мөнгөний хар шавраас зайлж чадахгүй байдаг. Шөнө дөлийн эхний зураглал нь бүх зохиолын үндсэн гүн аясыг илэрхийлж аж үйлдвэрийн, шанхайн мөнгөн гүйлгээний шөнө дөлийн уур амьсгалыг тусгасан байна. Шөнө дөлд: “Ү настан нүдээ бүлтийлгэн харав. Уур хилэн занал ба хэтэрхий шаталтаас болж царай нь халуураад хөхрөх боллоо. Зочдын танхимд өнгө бүрийн цахилгаан дэн гялалзан эргэлдэж эргэх тутам хурдан болж байлаа. Түүний дэргэд ойрхон нэг гялалзсан дугараг төмөрлөг жинтэй юм сор сор дуугарсаар бас зүүнш баруунш аажуухан сажилж хүний өөдөөс амьсгал бүтэм хүчтэй салхи үлээх нь төмөр нүүртэй ямар нэг буг чөтгөр толгойгоо сажлан увдис үзүүлэх мэт харагдана. ... улбар хувцастай Ү Суньфу-ийн эхнэр, алмараад ногоон өнгөтэй нэг бүсгүй, шаргал өнгөтэй ба нэг эмэгтэй, бүр хий солиотой юм шиг дэвхрэн үсэрлээ ! тэдний өмссөн нимгэн панс хувцас нүцгэн биеийг нь гүйцэд халхалж чадахгүй тул сартайсан хөх ув улаан хөхний товч ба суганых нь нарийн үс хүртэл ив ил харагдаж байлаа ! эдгээр сэртгэр торгон хүүхнүүдийн бүжиглэн эргэлдэх дунд

<sup>3</sup> 惠佳俞: 《茅盾小说中的革命叙事要素》, 南京师范大学硕士学位论文, 2017年, 第55页。



## THE CULTURAL WAY

Ү Сүньфу-ийн барзгар дөрвөлжин царай ба Энъ шюань-ий тэр шуналтай шуламсын харц хутгалдана. Тэгж байтал, цацран бүжиглэх, бүжиглэн эргэлдэж байсан тэр олон хүүхнүүд гэнэт яг самуун зэв шигээр Ү настны өвчүү цээж өөд нисэн ирж хуран хурсаар цээжин дээр нь дарж хүндрэн хүндэрсээр бас өвдөг дээрх < хурмаст тэнгэрийн соёрхол > дээр нь дарлаа. Тэгэхдээ бас л гэр дүүрэн зэвүүн инээд тачигнаж, гэр байшин унамаар нурмаар сажиллаа.” гэж Ү настны хөдөөнөөс хот орсон зам дагуу өнгө үзэмжийг зураглаж, шинэ соёл боловсныг хүлээн авч чадахгүй байгаа будлиант сэтгэлгээг тусгажээ.

Өнгөрсөн зууны 30-аад оны үед Шөнө дөл роман сэдэвлэхүүний талаар өргөц ихтэй, хэмжээ нь аугаа сүрлэг, агуулга нь элбэг баялаг байж, урлаг үзэл санааны хүч нь эн түрүүнд цаг үе нийгмийн амьдралтай нягт харьцаатай мөртөө нэлээд их агуулгатай, 30-аад оны үеийн нийгмийн байдлыг үнэн бодитойгоор зураглаж, тухайн үеийн нийгмийн хурц ширүүн зөрчил мөргөлдөөнийг илрүүлсэн байна. Шөнө дөл нь хувьсгалт уран зохиолын онол ба нийгэм журамт үзлийн бодит бичиглэлийг аргыг сүвэгчилж<sup>4</sup>, дундад улсын ойрх үеийн түүхийн шинэ нэгэн хуудсыг нээжээ. Мао Дүн-ий эрт үеийн бүтээлд гэрэл сацрангуйн дунд уйтгар гашуудлын сэтгэлгээ ч нуугдаж байдаг<sup>5</sup>. Фостер (福斯特 *fusite Stephen Collins Foster*)-оос “Туужсын тухай тал талын үзэлтэнд: туужис бол зохиогчийн тархин дахь бодит ахуйн дүрс зурагт нэг бага зүйлийг нэмэх ба нэг бага зүйлийг хасах аргаар бүрэлддэг” хэмээжээ. Мао Дүн-ий туужис бол жаахан давуулсан нэн олонх нь туйлширсан аргаар бичигдсэн байдаг. Шөнө дөлийн сэтгэлгээний дутагдал нь “5.4”-ний хөдөлгөөний бодгаль чанарын чөлөөлөлтийн гол сэдэвлэхүүний үргэлжлэл мөн. Шөнө дөлийн бүтэц нь сүлжээний бүтцийн нэгэнт тогтворжсон онол байж, нэн ч нэгэн гархин хэлбэртэй нийлмэл бүтэц болно<sup>6</sup>.

Романд: “Энэ хэрэг надад огтоос хачин санагдахгүй байна. Настан хөдөө нэгэнт < эртний хуучин үхдэл > болчихсон, гэтэл хөдөө бол хэрэг дээрээ зэлүүд далд < були > болохоор, үхдэл булины дотор < оршдог >-гүй байжээ. Одоо энэ шинэ цагийн их хотын шанхайд ирсэн юм чинь доороо < орших > нь зайлшгүй хэрэг. За хуучин болсон эртний нийгмийн үхдэл тонилтугай! Таван мянган оны үхдэл болсон хуучин дундад улс бас шинэ цаг үеийн салхи шуурган дунд удалгүй түргэн оршиж байхыг би олж үзлээ! Хурдхан тонилох болтугай!” гэж Ү овогтын оршуулгаар эхлэл болгож хуучин цаг үеийн эцэслэл хийгээд шинэ цаг үеийн хүрч ирэхийг бэлгэдэж, зохиолын гарчиг нь тухайн цаг үеийн нийгмийн харанхуй байдал ба хориглохын аргагүй гэгээн саруул ирээдүйг бэлгэджээ. Дундад улсын үндэстний хөрөнгөтөн ангийн дорой буурай чанар, хоёр талт чанар харьцуулшгүй чанар хийгээд урт хугацааны турш санаачилж байсан ахуйч үзлийн урлагийн үзэлтэй нь

<sup>4</sup> 孙中田著：《论茅盾的生活与创作》，中华书局，2015年，第113页。

<sup>5</sup> 夏志清著：《中国现代小说史》，复旦大学出版社，2005年，第114页。

<sup>6</sup> 徐德明著：《中国现代小说叙事的诗学践行》，社会科学文献出版社，2008年，第103页。



## THE CULTURAL WAY

зөрчилдөж байдаг. Энэ нь хүүрнэгчээс хажуугийн зураглалаар нэгэн уран сайхан арга барил даруй эхнээс нь дуустал нэвтэрсэн “гашуудлын ай” болсон байна, гашуудлын аяын хэсэг өндөржих хэсэг буурах нь ондоо нэг зүйлийн улс төр аж ахуйн хүүрнэлийн айзмын бэлгэ тэмдэг, зарим үед хүүрнэгчийн сэдвийн ил тодорхой бэлгэдлийн чанартай багаж болсон байна<sup>7</sup>.

*“Ямар үндэстэн, ямар анги давхарга, ямар хөдөлмөрийн гэрээ, хоосон үг, би зөвхөн мэдэх нь нэг улс. Харин улсын залуур нь заавал ган бат төмөр шиг алганд барих хэрэгтэй, хамгийн чухал нь бүтээхэд буй. Хоосон яриад байх биш!, харин ямарваа хүн энэ улсыг хамаарах төмөр алгыг эсэргүүцэж болохгүй!”* гэж улс төрийн эрх мэдэл нэг улсад хичнээн чухал гэснийг хөндсөн байна.

“Шөнө дөл”-ийн төгсгөлийн бүлэгт: *“ цагийн бүдүүн зүү есөд тэгнэн дуугарлаа. Энэхүү ган утасны цацраглан долгисох цэвэрхэн тод дуу эндэх өрөөний уурын тэрэгтэй Ү Сүньфу-ийн чихэнд сонстоход, түүний аньсан нүдний аньсага аяархан таталзав. ... зүүд зүүрмэглэлийн дунд, Ү Сүньфу тэр цагийн дохионы тодхон дууг бас олж сонссон байна, гэвч тэр энэ бачмаг давчуу зүгийн давчуу зөнгийн дуу арилжааны газар дахь хавтас цохих тавцангийн дээрх зөнгийн дуу, дэлгүүр эхлэх зөнгийн дуу, тэр нь Ү Сүньфу нарын шийдвэрлэх тулалдаан эхлэхийн дохионы бууны дуу болон сонстож байлаа.”* гэж Ү Сүньфу-ийн арилжаа дампуурсан ба түүний арилжааны ялагдлаас амиа хорлосон жич үндэстний хөрөнгөтөн ангийн аж ахуйн эцэс төгсгөлийг үзүүлж, зохиолын төгсгөлийн гунигт гүн аясыг чавхдаж байна.

“Морьт цэргийн дуулал”-д: *“Япончууд бууж өгөөд хагас жил болоогүй байхад Идэр хошуу нутгийн ах дүүгээ дагуулж хэд хэдэн бүлэг хулгай дээрмийг устган, малчдын мал сүргийг хамгаалсан болохоор Идэрийн оюун санаа, хатан зоригийг хүмүүс их магтдаг болсон юм. Тэгэхдээ малчид Идэрийг өргөж сайн дурын зэвсэгт хүчнийхээ ахлагч болгожээ. ”* хэмээн чөлөөлөгдөхөөс өмнөх япон цэрэг, Жян-ий дээрэм, Хө Фугүй-ийн түйвээнийг морьт цэрэг хэрхэн эсэргүүцсэн явцыг үзүүлсэн байна.

“Түүхийн цуурай”-д хүн чанар, хүний хувь заяаг тогтоож байгаа нийгэм, улс төр, анги давхаргын даралт, зааг шугамын хүчийг далдхан бэлгэдэв. Мөн зохиогчийн нэгэн сэхээтэн, бодлоготон хүний өрөвчхөн сэтгэлийн гүнээсээ хүн чанарын доройтлоос болсон гунигт хувь заяаны төлөө хашхирч байгаагаа бэлгэдэн харуулав. *“Урьддаа Солонгыг дотроо үргэлж бодож явж байсан ажиллах бригадын дарга Мандал түүний сүүмийн харж байгаа цоггүй болсон нүдийг удтал ширтээд дотроо < ай, хөөрхөн цэгцээхэй минь > гэж сэтгэл харамсан бодоод мөн ч бус дайсантай адил хоёр сум харваж нөхвөрлөхөө мартсангүй. Түрүүчийн сум нь түүний нарийхан цагаан бие дээр бараг цусгүй гэмээр бяцхан нүх гаргаж, хөхийг нь шувталсан дараачийн сумных нь шархнаас нэгэн дусал цустай сүү дааварлан гарч ирэв. ”* гэж чөлөөлөгдөхийн эхний жилүүдэд гоминданы хувьсгалын эсэргүү

<sup>7</sup> 徐德明著：《中国现代小说叙事的诗学践行》，社会科学文献出版社，2008年，第103页。



## THE CULTURAL WAY

этгээдийг арилгах хөдөлгөөний дундах эмэгтэйчүүдийн хувь заяаг дэлгэн үзүүлсэн байна.

“Нулимстай инээд”-д: *“Өвч зэвсэглэсэн эрчүүд Мядаг хөгшинийг бригадын байшин дээр аваачиж тусгаар нь нэг тасалгаанд хориод, тэр даруйд нь ээлжлэн дайралт явуулав. ... сүүлээр нь тэдгээр < тэргүүний туршилага >-тай тусгай хэргийн дугуйлангийн хүмүүс < малтаж арилгах > байлдагчдын сэнхрүүлэх ба бодитой хавсруулга доор хөгшиний тархи толгой жаахан сэхээрч, хэдийгээр < тушаах > үг хэлнийх нь ам сээр сайн золгохгүй, ухаан төхөө дамай олодохгүй боловч хувьсгалын зам өөд арай чарай хандаж анх алхам алхав. Чингээд Шэнь Жянь-ий бичиж таглаж өгсөн шинэ өвөр ардын намын хүснэгт дээр хуруугаа дарвайтал даржээ. Ингэснээс хойш малтаж арилгах байлдагчдын авах байдал нь өөрчлөгдөж, зодож цохих, харааж загнахаа больсон мөртөө өөд царай гаргаж тамхи цай уулгах болов. Чингээд хөгшин цааргалбал уучлах төрийн бодлогын ач тусыг цаг тухайд нь олж хүртжээ. ... ”* гэж үгээгүй ангийн соёлын их хувьсгалын үед ид хүчтэй өрнөсөн өвөр ардын намыг малтаж арилгах хөдөлгөөнийг нүдэнд үзэгдтэл зураглах, энэ хөдөлгөөний ял нүглийг илчлэн буруушаасан байна. Эдгээр туужист зарим улс төрийн хөдөлгөөн нь урт хугацааны үйлдлээр дамжаад нэгэнт буруу болчихсон байна. Гэтэл тэрхүү буруу хөдөлгөөнөөр сэдэвлэн бичсэн болбоос түүний харуулсан гол үзэл санаа нь тухайн үеийн улс төрийн хөдөлгөөн биш харин үнэн ба худал, хар ба цагаан, сайхан ба муухай ... болоход байгаа юм<sup>8</sup>.

“Алсын говьд”-оос өмнөх зохиолууд нь ардын үлгэрээс шим тэжээл хүртэж, үлгэрт суурилан бичсэн бол тус зохиолоос эхлэн дүрийг бүтээх талаар анхаарчээ<sup>9</sup>.

“Алсын говьд”: *“Алс хойд зүгийн сэрүүн тунгалаг уул мөрнийг зорьсон жаргалт халиун галуу үр төлөө дагуулан цэлмэг огторгуйд ганганан өнгөрч, хөвчийн өндөр оройгоос хөхөөн дуу сонстох нь хар хавсарга, хэцүү шүүргэ өнгөрөөд түмэн бодис амьдран дэлгэрэх тайван хавар эхэлсний бэлгэ тэмдэг болов”* гэж морьт цэргийн ялалттай урагшлан байх цэрэг ардын баяр бахдал бялхан байгааг галуу зулзагаа дагуулан нисэж байгаа ба хөхөө шувууны чөлөөт уяхан донгодоог дүрслэн баяр жаргалын бэлгэдэл болгов. Зохиогч урлагийн арга бүхнийг идэвхтэй хэрэглэж зохиолын баатрын зан чанарыг бүтээх дээр хүч тавьсан оролдлого тодхон харагддаг. Мао Дунь-ий “Алсын говьд” гэдэг өгүүллэгийн түүврийг уншаад: “Энэ зохиолын гуравдугаар бүлэгт орсон нь эхний үеийн бүтээлүүд багтана (1959 оноос өмнө), эдгээр нь нийтийн онцлогтой: үлгэр нь хүний сэтгэлийг хөдөлгөнө, байгаль орчин тойрныг бичсэн нь гойд сайхан ... 1959-1961 оны зохиол нь харин нэг том алхам дэвшсэн байна. Энэ нь гол төлөв дүр бүтээх ба бүх зохиолоо

<sup>8</sup> М.Жалибуха: “А.Одсэрийн зохиолын зохиомж ба сэдэв сонголтыг товч өгүүлэх нь”, МХУЗ, 1985.1 т 71.

<sup>9</sup> Сугараа: “А.Одсэрийн өгүүллэг туужийг үнэлэх нь”, Алтан түлхүүр, 1983.1 т 26.





## THE CULTURAL WAY

зохиомжлох явцад илэрч байна, бас яг энэ хоёр тал дээр зохиогчийн хувийн зохион бичих хэв суртал нь илэрч байна. Хэлэлгээнгүй, уянгын хувь ба хүсэнгүйч үзлийн гялбаа ч зохиолчийн хувийнх нь зохион бичих хэв сурталын нэг бүрэлдэхүүн болжээ хэмээн үнэлэн шинжилсэн байна. “Цогт ба түүний сартай хээр”-ээс эхлэн эерэг дүрийн баатрыг дүрсэлж, хувьсгалт тэмцлийг тусгахад анхаарсан байна<sup>10</sup>.

А.Одсэрийн туужист үндэстний ардчилсан хувьсгалын цаг үеийн өвөр монгол орны үндэстний чөлөөлөлтийн хөдөлгөөн ба орны өөртөө засах хөдөлгөөний хувьсгалт тэмцлийг тусгасан мөртөө нийгэм журамт хувьсгал ба нийгэм журамт бүтээн байгуулалтын цаг үеийн өвөр монгол орны маш чухал улс төрийн хөдөлгөөн ба аж ахуйн бүтээн байгуулалтыг тусгаж, тал нутгийн ардын цэргийн ангийн дайчин амьдралыг олон талаас нь дүрсэлсэн мөртөө малжих орны ард түмний цоо шинэ оюун санааны дүрс байдлыг нүдэнд ургатал зурагласан байлаа. Чөлөөлөх дайны үеийн өвөр монголын морьт цэргийн дайчин амьдрал тэмцлийг тусгасан цөөн хэдэн өгүүллэг нь эрэлхэг баатарлаг, сүрлэг жавхлантай аяс хүнгэнэн дуурсахаас гадна нийгэм журамт хувьсгал болон нийгэм журамт бүтээн байгуулалтын үеийн тал нутгийн ард түмний хөдөлмөр тэмцлийг тусгасан ихэнх өгүүллэг нь хоёр зам, хоёр зүйлийн үзэл санааны тэмцлийн оч гялалзан цацарч, тод тунгалаг, баяр баясгалант, зол жаргалын инээд хангинан цуурайтаж байдаг. Голдуу өвөр монголын тал нутгийн ард түмний дайчин тэмцэл дайны амьдралыг дүрсэлсэн юм. Одсэрийн өгүүллэг туужийн сэдэвлэсэн материал ба гол утга сэдвээс өвөр монголын саруул уудам тал нутгийн ард түмний сүр далайцтай хувьсгалт тэмцлийн түүхт зургийг тодхон олж харах юм. Сэдэвлэсэн материал, утга сэдэв дээр түүний зохиол бүтээлийн үндэстний онцлог шинж тодхон илэрч байх нь мэдээжийн хэрэг юм<sup>11</sup>.

Мао Дунь, А.Одсэрийн туужист цаг үе амьдралын алхаатай айзам зохицуулан, үлгэр үйл явдлыг хүүрнэж, утга сэдэвлэхүүний тэлэлтийг биелүүлсэн байдаг. Шөнө дөл романд дундад улсын 30-аад оны түүх, жижиг хөрөнгөтөн ангийн арилжааны ялагдал, мөнгөн гүйлгээний хямралыг тусгаж, Одсэрийн туужист 40-өөд оноос нааш дундад улсын 70 жилийн түүхт байдлыг тусгасан байна.

Хоёр. Байгаль ахуйн зураглал – агуулга бүтцийн бүрдэл

Шөнө дөлд нэг талаар зохиолын гол баатрын амьдрал хийгээд дотоод сэтгэлийг илэрхийлэх, нөгөө талаар байгалийн өнгө үзэмжийг зураглал нь бүхийл зохиол бүтээлд нэвтэрч, зохиолын бүтэц зохиомжид туслах үйлдэл үзүүлдэг. Эх байгалийн дүр зураглалын хөдлөнгүй чанараас нарийн зүйлсийн зураглалын урлаг ба баялаг урлагийн илэрхийлэх арга барил бүхий хэл

<sup>10</sup> Жаргал: “Тал нутгийн эрэлхэг баатарлаг охид хөвгүүдийн магтаал дуу – зохиолч А.Одсэрийн өгүүллэг туужийн тухай өгүүлэх нь”, ӨМБИСЭШС, 1979.1 т 1.

<sup>11</sup> Жаргал: “Тал нутгийн эрэлхэг баатарлаг охид хөвгүүдийн магтаал дуу – зохиолч А.Одсэрийн өгүүллэг туужийн тухай өгүүлэх нь”, ӨМБИСЭШС, 1979.1 т 1.



## THE CULTURAL WAY

хэллэгээр эх байгалийн орчин тойрныг зураглан, зохиол урлагийн агуулахууныг агуулж байдаг. Шөнө дөл романд: *“Арван долоо, салхи жаваргүй, цэнхэр хөх тэнгэрийн хөшгөнд хэдэн хэсэг цагаан үүл хөвөөд, үүлэн завсраар сарны инээмсэглэх мэт царай харагдана. Доод ертөнцийн нууц далдыг толилон үзэх нь тэр юм байжээ. Хуан фу мөрний ус яг гэрэл цацруулсан буурал шар өргөн бүс шиг нам дөлгөөхөн бөгөөд цог баясалтай урсана. Нэгэн багахан галт онгоц тэр гялалзсан мэлгэр усыг цалгиулж сүр жавхаатайгаар дуугарлаа. Онгоцны шал хавтасны дээр улаан ногоон жижицг цахилгаан дэнгүүдийг асааж, цэвэр сэлүүхэн шөнийн харанхуйд огторгуйн од мичидтэй мөчөөрхөнө. Энэ бол жарган цэнгэлдэгчдийн онгоц байжээ.”* гэж тухайн үеийн 30-аад оны үед шанхайн аж үйлдвэрийн хөгжил, байгаль ахуйн үзэмж байдлыг зурагласан байна.

Жинхэнэ урлагийн бүтээл бол агуулга ба хэлбэрийн бүрэн төгөлдөр нэгдэл мөн. Утга урлагийн бүтээлийн үйл явдал хийгээд бүтэц бол зохиол бүтээлийн үзэл санаа ба хүмүүсийн зан чанарыг илэрхийлэх чухал арга барил болно. Шөнө дөл нь нийгэм шинжлэх ухааны сэдэвлэхүүнээс гардаж хийсэн 20 дугаар зууны 30-аад оны дундад улсын нийгмийн шинж чанараас үзвэл, Мао Дүн-ий туужсын сэдэвлэхүүн ба нийгэм улс төртэй нягт холбоотой байдаг. Уран зохиол нь улс төрд үйлчлэхийн нийтлэг жишээ болно. Нийгмийн шинж чанарыг эзэмших талаар тухайн үеийн хамгийн ардчилсан марксын үзэлтэй хамгийн оновчтой чанарт хүрсэн байна. Мао Дүн бол “нийгмийг залах бүлэгтэн”-ий нийтлэг төлөөлөгч юм. Уран зохиолын анхаарлын цэг нь хүн, харин нийгэм ба түүх биш. Мао Дүн хуучин дундад улсын нийгмийн харанхуй бодит ахуйд ханамжгүй байгаа жич сайн сайхан ирээдүйн хүсэл эрмэлзэл, хувь хүний гутрангүй амьдралын бэрх тэвчээр жич оргилом сэтгэлгээ, сэдэлт өгөх хүслийн төлөө хувьсгалын хөдөлгөөнд оролцох болно. Шөнө дөлийн анхаарлын цэг нь сэхээтэн хувь хүний хувь заяа ба гарах зам нь улс үндэстний бодит байдал хийгээд гарах зам руу шилжсэн байна. Романд Ү настан, Ү Сүнфу, Жао Ботао, Ту Вэйюэ, Лү Заньмү зэрэг хүмүүсийн дүрийг амжилттай бүтээсэн байна.

Шөнө дөлийн эхлэлийн хэсэг: *“Тэнгэрийн хаяанаа оройн наран жаргаж, зөөлөн салхи хацрыг илбэнэ. Сүжсөү голын булингар ус цэлийн мэлтээнэж барууни алгуурхан урсана. Хуан фу мөрний оройн түлхээн гэнэт нэмэгдээд, Сүжсөү голын хоёр хөвөөн янз бүрийн онгоц бүр дээш хөөрч, онгоцны шал гармаас дээш хагас тохой хэртэй давж байлаа. Далайн хөвөөний цэцэрлэгийн хөгжмийн аялгуу салхины аяар цуурайтаж, буурцаг хуурах мэт нүржигнэн дуугарах бөмбөрийн дуу хамгаас тодхон сонсогдож, хүмүүсийн сэтгэлийг сэргээнэ.”* гэж тухайн үеийн шанхайн байгалийн өнгө үзэмжийг зурагласан бөгөөд Ү настны хөдөөнөөс хот орж, феодалын ялзармал үлдэгдэл хүч удалгүй мөхөх гэж байгаа, шинэ цаг үеийн үүрийн гэгээ удалгүй хүрч ирэхийг бэлгэдэн үзүүлсэн байна.



## THE CULTURAL WAY

*“Шөнө дөлийн арван хоёр цаг боллоо. Аж үйлдвэр мөнгөн гүйлгээний хот болсон шанхайн олонх хүмүүс цус махаараа тэмцэлдээний аймшигт зүүдэнд шанална. Шөнийн цуглааны газрын архины мухлаг дотор харин хутга сэрээний хангир цангир дуу ба архины лонхны таглааг авах чимээ нүс нүс сонсогдоно. Ү Сүньфу баруун гараараа архины хундагыг дарж, зүүн гараараа толгойгоо тулаад, архины мухлагт орж ирэх ба эндээс гарах хүмүүсийг дэмий л харж сууна.”* Ү Сүньфу-ийн аж үйлдвэрлэл хямрал гарсан жич хатагтайн ургийн гаднах хайр сэтгэлийн зүүдийг зэрэгцүүлэн зурагласан байна.

“Линь овогтын пүүс”-нд Тун жангуйт нарийн хянамгай, гэвч хөдөө тосгоны дампуурал, тариачдын худалдан авах чадвар доошилсон ба дайны нөлөөнөөс болж албан яамны хяхал мөлжил, адил үйлстний гадуурхал, түүний жижиг пүүс нь эцэстээ дампуурч үүдээ хаасан байна. “Хаврын хүр”-д Лао Тунбао-ийн нэг гэрийнхэн нэг сар зовуурь зүдгүүрээр хүрийн ширхэг элбэг хураалт олсон боловч гадаадын бараа борлуулалт сайтайгаас болж үндэстний нэхмэлийн үйлдвэр нь үүдээ хааж, хүр тэжээсэн хүмүүсээ алдаж, өрөнд унасан байна. “Шөнө дөл” нь 20 дугаар зууны 30-аад оны үеийн дундад улсын нийгмийн шинж чанарын эзэмдэл нь тухайн үеийн хамгийн ардчилсан марксын үзэлтэй адил оновчтой хэмжээнд хүрч, Хаврын хүр зэрэг бүтээл нь үнэн бодитоор тухайн үеийн хөдөө тосгоны элбэг хурааж гай болсон үзэгдлийг зураглаж, энэхүү үзэгдлийг буй болгосон үндэс шалтгааныг эрэлхийлсэн байна. Шя Жычин: “Хаврын хүрээс хүн чанар нэр төрийн магтаал дуу”-г олж харсан байна”<sup>12</sup> гэжээ. Хаврын хүр, Намрын хураалт, Хахир өвөл зэрэг зохиол нь хоцронгуй газар орны хоцронгуй тариачныг бичиж, хувьсгалын үзэл ухамсар, ангийн үзэл ухамсар зэргийг бичсэнгүй, эс тийм бол үнэн бодит биш болно. Хаврын хүр нь их хувьсгалын дунд сэхээтний хувь заяаны зураглалаар дамжиж, ухамсартай ба ухамсаргүй зүтгэлийн хооронд хот ба хөдөөгийн бүтцийн ухамсартай буюу ухамсаргүй ойлголтыг илэрхийлж, энэхүү зүтгэл нь их хувьсгалын ялагдлаас Мао Дүн-ий үзэл санаанд үзүүлсэн нөлөө тусгалыг харуулсан байна. Шөнө дөл нь үндэстний хөрөнгөтөн ангид Ү Сүньфу гол баатар болгож, харин ажилчин ард түмэн хийгээд ажилчны толгойлогч биш, Линь овогтын пүүс нь пүүсний жангуйт ба доод давхаргын үгээгүй ядуу ард түмнийг сонгосон байна.

А.Одсэрийн “Сувд цацсан тал”-д: *“Өглөөний гүн тунгалаг огторгуйд сэмжин цагаан үүл сэвэлзэн нүүсээр агаар тэнгэрийн алс хязгаарт арилан үзэгдэхгүй болно. Гэрийн тооноор эгц дээшээ суварсан аргалын цагаан утаа ч мөн хэсэг нимгэн мэт цайн тунарна. Тэнгэрийн зүүн хаяанаас аажмаар мандсан алтан туяа аварга том өнгөт хээр шиг тулалзахад, намрын ширүүн салхи талын бэлчээр ба хөдөө бэлчин яваа үхэр хонийг зөөлөн илбэн өнгөрнө. Голын хөвөөний цэвэр агаарыг амьсгалахад цээж онгойж, дотор их л аятай санагдана.”* малчдын тэргүүний ба хоцронгуй үзэл санааны зөрчлийг

<sup>12</sup> 阎浩岗著：《茅盾丁玲小说研究》，人民出版社，2018年，第9页。



## THE CULTURAL WAY

харуулахын хамт хоршооллын дараах хуучин хүчний аминч тулгамч үзлийг шүүмжилж, зохих хэмжээний ангийн тэмцлийг тусгажээ<sup>13</sup>. Хоршооллын хөдөлгөөний үед хонин сүрэг бэлчин, Наранцэцэгийн гараар хээлтүүлэх ажил амжилт олсон өнөр хөгжил байдлыг зураглаж, тэргүүний ба хоцронгуйн зөрчил, ангийн тэмцэл, Ганбуугийн ажлын байдал, намын зөв удирдлага зэрэг асуудлыг харуулжээ.

“Саруул нутгийн хүү”-ийн зохиолын эхэнд: *“Үүрийн гэгээ орж харь холын мянга түмэн од мичид огторгуйгаас ангижирч, өнгөт цолмон алсын агаарт нуугдав.”* гэж зураглан зохиолын төгсгөлд: *“Хоёул гар гараа чанга атгалцан алхахад тэдний өмнө хязгааргүй уудам саруул зээргэнтийн тал униартан, ариун тунгалаг хүнхэрийн голын ус цайлжсан харагдаж, өнгө бүрийн цэцэг хуар голын тохойг дагаж дэлгэрээд халуун жаварт сайхан үнэр анхилна. Дэнж дагаж суусан зуслангийн айлын өндгөн цагаан гэрүүд жигдлэн харагдаад, адуу хонин сүрэг өвст тал дүүрэн чимэглэжээ”* дээрэм дарах явдал бүх үлгэрээ холбон сэжимлэсэн байдаг. Саруул нутгийн хүүгийн аюулаас мултарч цэргийн хуарандаа буцсаны дараах баяр бахдалыг дүрсэлжээ.

“Морьт цэргийн дуулал”-д: *“Шөнө пад харанхуй, өвлийн хүйтэн амьсгал харганатай уулын ноён оргилоос бургастайн талыг өвч хамарлаа. Бөөн бөөн хар үүл цэвдэг хүйтэн тэнгэрийг нийт бүрхэж, үе үе ширүүн салхи цас бударган тал дээгүүр исгэрнэ. Ярайн түгсэн одон сүрэг алс хол анивчин гялалзана. Уул нурууд, дов долоон цөм харанхуй шөнийн хахир шуурганд далд оржээ. Гайгүй сайн ажиглавал замын хажуу дахь навтгар жижижсэн ололжин гэр, уван цуван буусан монгол гэрүүд л энд тэнд бүртэлзэнэ. Улай эргэсэн өлөн чонын улих дуун тасралгүй сонстоно.”* морьт цэргийн дайны үеийн зураглалаар орчин тойрны хэцүү бэрхшээлтэй, аймшиг сүрдүүлэлтэй ахуй орчныг тусгаж, морьт цэргийн эрэлхэг баатарлаг зориг сөстэй байдлыг тусгасан байна. Романд аж амьдралын бүх бүдүүлэг, оршин тогтнолын мөн дүрс болон тэд нутгийн өнгө үзэмж нь хүмүүсийн дурыг булааж, гуньж баярлах, догдолж зовох санаа сэтгэлийг өөрийн эрхгүй ундруулдаг.

“Инээлцэн урсах рашаан гол”-д: *“Их байгалийн өвөрт зуу мянган жил нойрссон хүмүүс, одоо үеийн боловсны хориглагдашгүй хүчит урсгалд цочисхийн сэргижнэлээ. Өөрчлөлт нээлтийн үеэс голын хоёр хөвөөний тал нутаг хөөр хөгжөөнөөр бялхав. Өнгөрсөнд зөвхөн давсны аяны үхэр тэрэг, их говийн тэмээн жин л цувдаг байсан ханагар талын харгуй замаар зүйл бүрийн машин тэрэг зөрөлдөн цуварч, моторын дуу өдөржин шөнөжин хүржигнэн дүнгэнэж нарлаг талын нам сэлүүнийг түргэн донсолгож эхлэв”* гэж шинэ эринд рашаан голын хөвөө дагуу орны хүн зоны үржил төлжил, амьдрал эснэлийг зураглав.

“Цэнхэр долгионт рашаан”-д: *“Хөхрөн харагдах хан хайрханы ноён оргил өглөөний наран өөдөөс улбар саа нөмрөн мишээнэ. Монгол гэрийн тооноор манаран дэгдэх аргалын галын цайвар утаа рашаан голын мөнгөн*

<sup>13</sup> Сугараа: “А.Одсэрийн өгүүллэг туужийг үнэлэх нь”, Алтан түлхүүр, 1983.1 т 31.



## THE CULTURAL WAY

долгиог илбэн уудам талын ханагар өрцөнд замхарна. Голын баруун тэртээх өлөн хиагийн дунд дөч тавин хүмүүс тэнгэрийн од шиг энд тэнд бутран уван цуван хөдөлж харагдана. Эрчүүд нь ханцуй шамлаж бүсгүйчүүд нь хормой шуун сандуу эргүүлэн хадландаа мэрийнэ. ... өвсөн довын арын шаагим ногоон хиагт бие бялдартай хүдэр хар залуу дээд биеэ нүцгэлж өвс ширвэн хүчээ шалгана. Хурц сандуу нь наранд гялс гялс гялалзаж хүрэн бор зоог нь дагаж хөлс нь урсаад хөлөг хөлөг гөлтгөнөнө.” гэж монгол нутаг, монгол орны амьдралын зураглалаар монгол амьдралын өөд эсрэг, амьжрал эснэлийг бэлгэдэн харуулжээ. “Он сарын олон мөр”-д: “Тавдугаар сарын Баарин талын нутаг, номин ногооноор цэлгэрч, соргог сайхан уур амьсгал сэтгэлийг минь тэнийлгэнэ. Замын хажуугаар цахирмаа цэцэг хөхрөн дэлгэрээд өвс ногоон дунд элдэв өнгийн цэцэг хуар алаглан харагдаж, зөөлөн салхинд нааш цааш найган ганхаад анхилмал сайхан үнэр ханхална. Тэртээх талын алс хязгаарт харагдах үүлэнд шургасан ноён оргил бол даруй миний төрсөн нутгийн богд оргил сайхан хан уул болно. Уулын ар дахь үзэсгэлэнт сайхан жалга бол даруй миний унаган багаасаа хөл нүцгэн хурга тугалаа хариулж явсан торгон зөөлөн бэлчээр юмсан. ” гэж өнгөрсөн зууны 40-өөд оны үеийн баарин нутгийн зураг шиг ертөнцийг дэлгэн үзүүлж, нутаг усны тухай хайр сэтгэл шингэж байдаг. Шөнө дөлийн байгалийн ахуй зураглал нь үлгэр үйл явдлын үүсэл хөгжилд суурь тавин өгч, орчин тойрны зураглалаар зохиолын хөг амьсгааг чангаруулж, үйл явдлын төгсгөлд үйлчлүүлсэн бол А.Одсэрийн туужист байгаль ахуйн зураглал нь мөн монгол нутгийн байгаль ахуйг уншигчдын өмнө дэлгэж, 40-өөд оны үеийн гоминданг эсэргүүцэх монгол морьт цэргийн дайны байдал, үлгэр үйл явдлын үүсэл хөгжилд үйлчлүүлсэн байна. Ямарваа зохиол бүтээл нь гагцхүү аль чадахаар үнэн зөвөөр байгаль ахуйг зураглах үес сая зохиомол шинжтэй болдог. Иймээс уран зохиолын зохион бүтээлт нь түүхэн ондоошил ба түүхэн хүслэнг агуулж байдаг.

### **Гурав. Эмэгтэйчүүдийн тухай сэдэвлэхүүн – утга сэдэвлэхүүний тэлэлт**

А.Одсэрийн туужис туурвил, ялангуяа шинэ эриний зохиол бүтээлдээ эмэгтэйчүүд ба хайр дурлал гэр бүлийн харьцааг шинэ цаг үеийн байдалд тусган үзүүлж, хайр дурлал, гэр бүлийн асуудалд үүссэн шинэ эриний эмэгтэйчүүдийн үзэл ойлголт, үйл ажиллагаа зэргийг тусгасан байна. Түүний туужист илрэх эмэгтэйчүүдийнх ихэнх нь шинэ үзэл ухамсартай, өөрийн гэсэн үзэл бодолтой, хүслийнхээ төлөө хичээж, чөлөөт хайр дурлалыг хөөцөлдөж, бас гэр бүлийн үүрэглэвээс зохих хариуцлагаа үүрэглэдэг шинэ цаг үеийн эмэгтэйчүүдийн дүр болно. Үүнд, эмэгтэйчүүдийн тухай сэдэвлэхүүний талаар Мао Дунь ба Одсэрийн туужист адил шинж илэрсэн байна.

Эмэгтэйчүүдийн зохион бүтээлт хийгээд ялгаа нь сэдэвлэхүүний тал дээр байгаа биш, харин эмэгтэйчүүдийн дутуулаг үзэл бодол ба хувь хүний чээжлэхүй, хувь хүний оршихуйн туршлагаар амьдралын хэмжээн дэх сэдэвлэхүүнийг шийдвэрлэдэг<sup>14</sup>. Уран зохиол нь хүний амьдралаас эх

<sup>14</sup> 刘思谦: 《女性, 妇女, 女性主义, 女性文学批评》, 《南方文坛》, 1998年第2期, 第62页。



## THE CULTURAL WAY

үндэстэй мөртөө хүн чанарын олон талт шинж нь гадаад дотоод, хятад монгол уран зохиол дахь мөнхийн сэдэвлэхүүн болж бичигдсээр ирсэн юм. Мао Дүнь ба А.Одсэрийн туужсын зохиол дахь эмэгтэйчүүдийн ухамсар нь хүн чанарын мэдрэмжид шамдан орсон байна.

Эмэгтэйчүүдийн уран зохиол гэдэг бол эмэгтэйн эрхийн онолын дагуу гарч ирсэн уран зохиолын үзэл урсгал буюу зохион бүтээх хэлбэршил. Энэхүү үзэл урсгал өрнө дахинд анх буй болж, 20 дугаар зууны 80-аад оноос эхэлж дундад улсын уран зохиолынхонд дуу шуугиантай болжээ. Эмэгтэйчүүдийн уран зохиолын хамгийн ил тод онцлог бол эзэнт биет ухамсар ба шүүмжлэх ухамсар болно<sup>15</sup>. Эмэгтэйчүүдийн ухамсар нь өрнө дахины эмэгтэйчүүдийн үзлийн утга зохиол, эхийн эрхт үзлийн утга зохиол ба эмэгтэйчүүдийн ухааны судалгааны эхлэлийн цэг бас ч гол цөм мөн. Утга зохиол нь хүний үзэл ухамсрын гадагшлал илэрхийлэл мөн болохоор эмэгтэйчүүдийн утга зохиолд эмэгтэйчүүдийн бүх зүйлийн ухамсрыг илрүүлэх нь утга зохиолын хөгжлийн аажим жам юм. Гэхдээ эмэгтэйчүүдийн утга зохиол дахь эмэгтэйчүүдийн ухамсрын илрэл бодит байдалд буюу ухамсрын хүчлэц, ухамсрын хэр түвшин нь цаг үеийн ба улс үндэстний гэх ялгаа зөрөө байна. Энэхүү ялгаа зөрөө нь улс үндэстний нийгэм улс төрийн байдлаас тогтоогдохоос гадна эмэгтэйчүүдийн утга зохиолын өөрийнх нь хөгжлийн байдалд ч холбогдоно<sup>16</sup>.

Мао Дүнь залуу сэхээтэн эмэгтэйчүүд онцгойлон “шинэ эмэгтэйчүүд”-ийг бичихээр алдаршиж, зохиол бүтээлдээ сексийн зураглалыг тодруулдгаараа хүмүүсийн зэмлэлийг ч хүртсэн байна. Шөнө дөл романаа Мао Дүнь өргөн хэмжээгээр дундад улсын нийгмийн бодит ахуйг зураглах ном гэж төсөөлж байсан боловч Ү овогтын ордноор төв болгож, дээд давхаргын нийгмийн бүх төрлийн бүсгүйчүүд ба сэхээтний дүрийг бүтээсэн байна. Тэд өөрийнхөө үзэл санааны хэв төрхтэй байж, адил бус хэмжээнд “Шөнө дөл”-ийн нийгмээс тэдний хязгаарлал ба нөлөө тусгалыг илрүүлсэн байна. Мао Дүнь зохион бүтээлтийн дундаа эмэгтэйчүүдийн дүрээр цаг үеийн онцлогийг харуулж, дотоод сэтгэлийн зураглалаар эмэгтэйчүүдийн дүрийг бүтээх зэрэг онцлогтой байдаг. Хувьсгалыг нэг ч ойлгохгүй хамгийн эцэст хувьсгалын замд орсон сэхээтэн залуу эмэгтэйн дүр буй. Дотоод сэтгэлийн нарийн зураглал бол Мао Дүнь-ий зохиол бүтээлийн нэгэн онцлог болно. Мөн ч Шөнө дөлийн нэгэн илэрхий урлагийн онцлог болно. Шөнө дөлийн гол баатрын үг яриа нь хүмүүсийн үзэл ухамсар, үзэл сэтгэлгээ, хэв боловсрол, дотоод сэтгэлийн байдлыг нэлээд оновчтой илэрхийлсэн байна. Шөнө дөлийн хүмүүсийн хэлний онцлог нь мөн ч нэлээд өндөр хэмжээтэй байдаг. Зохиогч эрт үеийн бүтээлдээ дотоод сэтгэлийн зураглалыг гүнзгий зураглах чадвартай байдаг. Шөнө дөлд ажилчны хөдөлгөөнийг нууцаар төлөвлөхийн дагуу, сексийн

<sup>15</sup> Сараана: “Зөн билгийн монгол уран зохиол”, ӨМИСХХ, 2009 т 308.

<sup>16</sup> Гэгээнсар: “Монгол уран зохиолын шүүмжлэлийн үзэгдэл судлал”, ӨМАХХ, 2011 т 82.





## THE CULTURAL WAY

талаар дур зоргын байж, хүмүүсийг сандаргах буюу бухимдал хүргэх нь үргэлж харагдана<sup>17</sup>.

Шөнө дөл бол манай улсын орчин үеийн уран зохиолын түүхэн дээрх чухал нэгэн иж бүрэн ойр үеийн хүн соёлын үзэл санааны зогсцоос дундад улсын ойр үеийн соёлын эртний сонгодог хүн соёл үзэл санааны аугаа их түрэлтийг үнэн бодитой гүн гүнзгий тусгасан амжилттай бүтээл байж, дундад улсын хүний ойр үечлэлийн сүвэгчлэлд олтгойлж болшгүй хувь нэмэр үзүүлжээ<sup>18</sup>. Мао Дүн-ий өмнөх үеийн эмэгтэйчүүдийн үзэл бол түүний зохион бүтээлтэд нөлөө тусгалтай байдаг. Эмэгтэйчүүдийн ухамсар бол цөм болно. Бодит агуулагдахуун нь хүний өөрийн ухамсар, бие махбод ба аж ахуй улс төрийн талын харьцуулшгүй тусгаар биеэ даах, хайр сэтгэлийн ариун нандин, хайр дурлалаар суурь болгосон ураг хурим ба шинэ сексийн ёс суртахуун, хэсэг талын эш ёсны үзэл, эмэгтэйчүүдийнхээр төвлөх хэлбэр бүхий хэлбийхийг засах гээд хэтрүүлэхийг эсэргүүцэж, нийгмийн өөрчлөлт бол шинэ эмэгтэйчүүдийн өөрийн биеэ биелүүлэх үндсэн зам мөн<sup>19</sup>. Шөнө дөл бол ахуйч үзэл ба эдүгээч үзлийн уусалцлын талст мөн. Шөнө дөл нь Мао Дүн-ий туужсын урлагийн чанга хүчтэй оюунч төсөвлөлийн чадавхийг илэрхийлж, зохиогчийн мэдрэхүйн урлагийн баялаг туршлага агуулагдаж байдаг<sup>20</sup>.

